

Гепатит дельта – энгийнээр тайлбарлавал

Гепатит Д вирусийн шинжилгээ ба оношилгоо

Өвчний хүнд явцыг зогсоохын тулд гепатит Д-г эрт үед нь илрүүлж, эмчилж, эмчилгээнд хяналт тавих шаардлагатай гэдгийг мэдэх нь чухал юм.

■ Шинжилгээг хэзээ өгөх вэ? **

- Дараах шинж тэмдгүүд илрэх үед:
Шаралт, ядаргаа, шээсний өнгө өтгөн болох, өтгөн цайрах, хэвлийн баруун дээд хэсгээр даралт мэдрэгдэх.
- Гепатит Б вирусийн халдвар авсан байгаа тохиолдолд Д вирусийн шинжилгээг өгөх.
- Халдвартай хүнтэй цус болон биеийн шингэн холилдсон гэж үзэж байвал.

■ Шинжилгээг хэрхэн хийх вэ? *


- Эмчийн өрөөнд таны цуснаас шинжилгээ авч вирус бүрэлдэхүүн эсвэл эсрэг биет байгаа эсэхийг шинжилнэ.
- Хэрэв эсрэг биетийн шинжилгээ эерэг гарсан тохиолдолд, ПСР буюу дараагийн шатны шинжилгээг авдаг.

■ Оношилгооны дараа яах вэ?

Ерөнхий мэргэжлийн эмч нар өвчтөнийг элэгний нарийн мэргэжлийн эмч рүү шилжүүлнэ. Тэд хамтдаа эмчилгээ болон эмчилгээний төлөвлөгөөг боловсруулна.

■ Гепатит Д-н халдварыг эмчлэхгүй тохиолдолд яах вэ? *

- Гепатит гэдэг нь элэгний эсийн үрэвслийг хэлнэ.
- Үрэвсэл нь фиброз гэж нэрлэх хэвийн бус холбогч эдийн бөөгнөрлийг үүсгэдэг.
- Хэрэв үрэвсэл даамжирсаар байвал элэгний эсүүд үхэж, сорвитой эдийг бий болгоно.
- Энэ сорвийг элэгний хатуурал гэж нэрлэдэг. Ингээд эд хатуурснаар элэгний хатуурал үүсгэж элэг өөрийн үүргээ гүйцэтгэж чадахаа больдог. Улмаар элэгний дутагдал, хорт хавдарт хүргэнэ.



content liability:

Kautz⁵ gUG
Hauptstraße 335 · 51143 Köln
post@kautzhoch5.de · www.kautzhoch5.de



in cooperation with:

World Hepatitis Alliance

with kind support of:

MYR MYR Pharmaceuticals

MYR GmbH ist jetzt eine Tochtergesellschaft von Gilead Sciences, Inc.